



УДИРДАМЖ

2022 оны 03 дугаар сарын 09

Чингис хот

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУХАЙ

Зорилго: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөн туслах

Хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 16-наас 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрүүдэд багтаан явуулна.

Ажиллах хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Г.Уянга	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
	Ж.Цэнджав	Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн

С.Лхагвацэрэн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Хамрах хүрээ: Эрүүл мэндийн газар, Боловсролын газар

Хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тэдгээрийг хяналтад авсан байдал
2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт

3. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

4. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, түүний ажлын төлөвлөлттэй уялдсан байдал

5. Төрийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт

6. Салбарын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний төлөвлөлт

7. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт

8. Байгууллагын дарга болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөө, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо

Жич: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж дүгнэнэ.

Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

